



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/1193

Баянтал сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1,23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ний өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.5, 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засаг даргын зөвлөлийн 2024 оны 10 дугаар ээлжийн хуралдаанаар хэлэлцэгдэж дэмжигдсэн арга хэмжээнүүдэд 20,000,000 (хорин сая) төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Дээрх зардалд шаардагдах 20,000,000 (хорин сая) төгрөгийг Сумын Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын ерөнхий нягтлан бодогч (Х.Ариунгуа)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын даргыг үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ш.Шинэбаяр)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Э.БАТТУЛГА

Арга хэмжээний зардал

№	Арга хэмжээ	Тоо ширхэг	Төсөв	Нийт
1	Ерөнхий боловсролын сургууль	1	1,000,000	1,000,000
2	Сүү хөтөлбөр /Ерөнхий боловсролын сургууль/	1	1,119,400	1,119,400
3	Эрүүл мэндийн төв	1	1,000,000	1,000,000
4	4-р Цэцэрлэг	1	300,000	300,000
5	Ахмадын баяр арга хэмжээ	1	1,346,000	1,346,000
6	Мини камер	1	2,500,000	2,500,000
7	Хамтарсан багийн үйл ажиллагааны төсөв	1	1,000,000	1,000,000
8	Шатахуун /Засаг даргын Тамгын газар/	1	1,000,000	1,000,000
9	Автомашин засвар /Засаг даргын Тамгын газар/	1	2,000,000	2,000,000
10	Сумын Засаг даргын жуух бичгийн дагалдах мөнгөн урамшуулал	3	55,000	165,000
11	Сумын Засаг даргын жуух бичиг	1	100,000	100,000
12	Сумын цагдаагийн police наалтны төлбөр	1	185,000	185,000
13	Мал, хүн амын тооллогыг зохион байгуулах төсөв	1	1,284,600	1,284,600
14	Оюунтны сургалтын тэтгэмж	5	1,000,000	5,000,000
15	Сонгуулийн сурталчилгааны хар самбарын төлбөр	1	2,000,000	2,000,000
Нийт			20,000,000	



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/144

Баянтал сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.3, 48 дугаар зүйлийн 48.2.1, Баянтал сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн “Сумын 2024 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 06 дугаар тогтоолыг 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 2024 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-гийн хөрөнгөөр хийгдэх “Өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Ш.Шинэбаяр (Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүн:

Т.Ган-Эрдэнэ (Их-Уул багийн Засаг дарга)

Нарийн бичгийн дарга:

М.Бодьгэрэл (Нийгмийн бодлого, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулахыг ажлын хэсгийн дарга (Шинэбаяр)-д үүрэг болгосугай.

3. Ажлын хэсгийн зөвлөмжид үндэслэн шалгарсан гүйцэтгэгчийн гэрээний биелэлтэд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Баянтал сумын Засаг даргын орлогч (Э.Эрхэмбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ

ГҮЙЦЭТГЭГЧ

Э.БАТТУЛГА



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 08 өдөр

Дугаар А/145

Баянтал сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн “Сумын 2024 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах” тухай 20 дүгээр хуралдааны 6 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын “Спорт заалны барилгыг шинээр барих” ажилд зориулж 7,050,000 /долоон сая тавин мянга/ төгрөгийг хөрөнгө зарцуулсугай.
2. Дээрх хөрөнгийг 2024 оны сумын төсөвт тусгагдсаны дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн зардлаас санхүүжүүлэхийг санхүү албаны ерөнхий нягтлан бодогч (Б.Солонгомаа)-д даалгасугай
3. Захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Э.Эрхэмбаатар)-д үүрэг болсугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Э.БАТТУЛГА



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 08 өдөр

Дугаар 4/46

Баянтал сум

Д.Нанжидын асран хамгаалагчаар
Д.Мөнхзулыг тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Гэр бүлийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.3, 65.1.5, 67 дугаар зүйлийн 67.1.1, 71 дүгээр зүйлийн 71.1.1, 73 дугаар зүйлийн 73.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын 1-р багийн иргэн Эрэнгийнхэн овогт Дашдаваагийн Нанжид (ЗП48090309) нь хөгжлийн бэрхшээлтэй тул харгалзан үзэж, түүний төрсөн охин болох Угтаал аривжих овогт Дагдангийн Мөнхзул (ЗП79092106)-ыг асран хамгаалагчаар тогтоосугай.

2.Асран хамгаалагч Д.Мөнхзулд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн халамжийн мэргэжилтэн (С.Мөнхсаруул), 1-р багийн Засаг дарга (Э.Түмэн-Эрдэнэ) нарт үүрэг болгосугай.

3.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүрэг гүйцэтгэгч (Ш.Шинэбаяр)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Э.БАТТУЛГА



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 07 өдөр

Дугаар А/147

Баянтал сум

Түр нүүлгэн шилжүүлэх талбайтай
болох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг, дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.21, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны Ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Гамшиг осол тохиолдсон үед сумын хүн амыг түр нүүлгэн шилжүүлэх байршуулах талбайг хавсралтаар баталсугай.

2. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт хяналт тавьж, бэлэн байдлыг хангаж ажиллахыг Мэргэжлийн ангийн дарга бөгөөд удирдлагын байрны дарга (Ш.Шинэбаяр), сумын онцгой комиссын орлогч дарга (Э.Эрхэмбаатар) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА  Э.БАТТУЛГА



Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 07-ны
өдрийн 7/14 тоот захирамжийн хавсралт



Баянтал сумын Түр нүүлгэн шилжүүлэх талбай байрлал


№	Газрын нэр	Координат
1	Лүн баг	46°36'24 N 108°19'03 E

Болал тухай

Монгол Улсын Засаг даргаас нутаг дэвсгэрийн нэгж, түрний үйлдлийн
түний хуулийн 58 дугаар зүйлийн 59.1.21.55-1.23, 60 дугаар зүйлийн 60.1
дугаар хэсгийн Ерэнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1
Галшгаас хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 32 дугаар зүйлийн
32.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Ганцаж өмчлөх тусгаарлагдсан үед сумын хүн амыг түр нүүлгэн шилжүүлэх
байрнуудыг талбай хангалуур баталнагуй

2. Байрнуудыг тусгаарлагдсан хяналт хяналт тавьж, болон бэлдлэг хөнгөн
мөхлөгөөр тусгаарлагдсан үед дэргэ бөгөөд удирдлагын байрны дэргэ
(10 Шалтгаар) тусгаарлагдсан үед тусгаарлагдсан үед дэргэ (3.Эрэмбэтээр) нэгт зүйлийг
түр нүүлгэн шилжүүлэх





ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/148

Баянтал сум

Захирамж хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1 Газрын тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1. дэх заалт, Говьсүмбэр аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2024 оны 113/ШШ2024/0022 захирамжуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Баянтал сумын Засаг даргын 2020 оны А/90 дугаар “Газар эзэмших эрхийг хүчингүй болгох тухай” захирамжийг хүчингүй болгож Цацалмон ХХК-д (РД:2085801) үйлдвэрлэлийн зориулалтаар 1 га газрыг эгүүлэн сэргээсүгэй.

2.Хуулийн дагуу эзэмших эрхийг эгүүлэн сэргээсэн газрынхаа орчны тохижилтыг сайжруулж, зүй зохистой ашиглахыг иргэн “Цацалмон” ХХК-д үүрэг болгосугай.

3.Газар эзэмших эрхээ сэргээн авч буй иргэн “Цацалмон” ХХК-д газар эзэмших эрхийг нөхөн бүрдүүлэх, хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг газрын даамал О.Энхзул үүрэг болгосугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 14 өдөр

Дугаар А/149

Баянтал сум

Өвөлжилтийн бэлтгэл хангах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 2024-2025 оны хөдөө аж ахуйн болон төв, суурин газрын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Э.Эрхэмбаатар (Засаг даргын орлогч)

Гишүүд:

Ш.Шинэбаяр (Засаг даргын тамгын газрын даргын үүрэг гүйцэтгэгч)

Э.Түмэн-Эрдэнэ (Лүн багийн Засаг дарга)

Т.Ган-Эрдэнэ (Их Уул багийн Засаг дарга)

Д.Цэрэнням (Ерөнхий боловсролын сургуулийн захирал)

Б.Энхмэнд (Цэцэрлэгийн эрхлэгч)

Б.Баярбаатар (Эрүүл мэндийн төвийн дарга)

Х.Энхжаргал (Соёлын төвийн дарга)

А.Батжаргал ("Талын-илч" ОНӨААТҮГ газрын захирал)

Ц.Лхагвадонид (Байгаль орчны мэргэжилтэн)

С.Оюунтүлхүүр (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:


О.Дөлгөөн (Хууль эрх зүйн мэргэжилтэн)

М.Бодьгэрэл (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

2. Сумын өвөлжилтийн бэлтгэл хангуулах ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3. 2024-2025 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг бүрэн хангуулах, хяналт тавих, шаардлагатай арга хэмжээг шуурхай зохион байгуулж, үр дүнг тайлагнахыг ажлын хэсгийн дарга (Э.Эрхэмбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА

Засаг даргын 2024 оны 10 сарын 14-ны дүгээр захирамжийн хавсралт

БАТЛАВ

ЗАСАГ ДАРГА Э.БАТТУЛГА

2024 оны 10 сарын 14 өдөр

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН БАЯНТАЛ СУМЫН ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТЭЛ

ХАНГАХ 2024-2025 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийгдэх ажлууд	Эцсийн хугацаа	Хариуцах байгууллага
Мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл алыг хангах			
1	Засгийн газрын тогтоолын дагуу аймаг, сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх	10 Сар	Байгууллага, аж ахуй нэгжийн дарга, захирал
2	Мал үржлийн болон биотехнологийн ажил, үйлчилгээг гүйцэтгэх.	10 сар	Хөдөө аж ахуйн тасаг, Батийн Засаг дарга нар
3	Бэлчээрийн даац багтаамжийг тооцох, отор хийх өрх, малын тоог нарийвчлан гаргаж, отор нүүдэл хийх чиглэлийг тогтоон аймаг, сумын удирдлагатай гэрээ хэлцэлийг хийж отор нүүдлийг нэгдсэн зохицуулалтаар зохион байгуулах	11 сар	Хөдөө аж ахуйн тасаг, Батийн Засаг дарга нар
4	Малчдад малын индексжүүлсэн даатгалын ач холбогдлыг тайлбарлан ойлгуулах, сурталчилан таниулах ажлыг зохион байгуулж малын индексжүүлсэн даатгалд малчдыг хамруулж, эрсдэлийг бууруулах.	11 сар	Хөдөө аж ахуйн тасаг, Батийн Засаг дарга нар
	Аймгийн хэмжээнд дэх мал сүргийн 10 хувийг хамруулсан байна.		

5	Мал сүрэгт намрын ангилалт, заазлалт, угаалга, туулгалт, вакцинжуулалтын ажлыг технологийн дагуу хугацаанд нь чанартай хийх, өвөлжөө, хаваржаанд ариутгал, халдваргүйжүүлэлтийг холбогдох журам, зааврын дагуу зохион байгуулах.	10 сар	Хөдөө аж ахуйн тасаг, Багийн Засаг дарга нар
6	Малын гоц халдварт өвчний эрсдэл бүхий сумдын малыг вакцинжуулалтанд бүрэн хамруулах, халдвар гарах эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг иж бүрнээр авч хэрэгжүүлэх	11 сар	Хөдөө аж ахуйн тасаг, Багийн Засаг дарга нар
7	Орон нутгийн түвшинд хээлтүүлэгч малын хүрэлцээг судлан дутагдаж байгааг чанартай хээлтүүлэгчээр хангах, мэргэжлийн ажил үйлчилгээг зохион байгуулж хэрэгжүүлэх	11 сар	Хөдөө аж ахуйн тасаг, Багийн Засаг дарга нар
8	Байгаль цаг агаарын аюулт үзэгдэл /үеэр, усны аюул, мөндөр, хүчтэй шороон болон цасан шуурга, хээрийн түймэр г.м/-ээс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг аймаг, сум, багийн холбоогоор малчид, тариаланчид, иргэдэд байнга хүргэж, сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах	Тухай бүр	Сумын ЗДТГ, Хөдөө аж ахуйн тасаг, Багийн Засаг дарга нар
9	Ургац хураалтад ажиллах хүн хүч, техникийн бэлтгэл, зохион байгуулалтыг хангуулах	10 сар	Хөдөө аж ахуйн тасаг, Багийн Засаг дарга нар
10	Малчид, мал бүхий иргэдийг өөрсдийнхөө хэрэгцээнд зориулсан хадлан, гар тэжээл бэлтгүүлэх	11 сар	Хөдөө аж ахуйн тасаг, Багийн Засаг дарга нар
11	Отроор өвөлжих, хаваржих малчдыг эрүүл мэндийн даатгалд заавал хамруулах	3-р улирал	Хөдөө аж ахуйн тасаг, Багийн Засаг дарга нар, Эрүүл мэндийн төв

Төв, суурин газрын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах			
12	Сургууль, цэцэрлэгийн урсгал засварын ажил, анги танхим, өрөө тасалгааны цонх, гадна хаалганы дулаалга хийж, эвдэрч хэмхэрсэн ширээ сандлыг засварлах, хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажлыг хангах	10 сар	Байгууллага, аж ахуй нэгжийн дарга, захирал
13	Халаалтын зуухнуудын их засвар, өргөтгөлийн ажлыг чанартай хийж, 10 сарын 01-ээс 05 сарын 01-ний өдрийг хүртэл дулаанаар хангах ажлын бэлтгэл хангах, нүүрсний нөөц бүрдүүлэх.	10 сар	Талын илч ОНӨААТҮГ,
14	Албан байгууллага, аж ахуйн нэгж байгууллагуудын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах	10 сар	Сумын ЗДТГ
15	Нийтийн эзэмшлийн орон сууцнуудын дулаан алдагдалыг бууруулах, орцны халаалт, цонх, хаалга, гэрэлтүүлгийг засварлах, сайжруулах	10 сар	Сумын ЗДТГ,
Өвөлжилтийн бэлтгэл ажилтай танилцах			
16	Ажлын явцтай танилцах, заавар, зөвлөгөө өгөх, хамтран ажиллах	Тухай бүр	Сумын Засаг дарга, Орлогч дарга
17	Өвөлжилтийн бэлтгэл, бэлэн байдалтай танилцах, үнэлэлт дүгнэлт өгөх	11 сар	Ажлын хэсэг

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН:
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН МЭРГЭЖИЛТЭН

О.ДӨЛГӨӨН



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 16 өдөр

Дугаар А/150

Баянтал сум

Газар эзэмшүүлэх, ашиглуулах
дуудлага худалдаа явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дугаар зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.2, Засгийн Газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”, Засгийн газрын 2024 оны 74 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт, Баянтал сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баянтал сумын 1 дүгээр багийн 152 дугаар байрны зүүн талд автомашины гаражийн зориулалтаар 0,022га газрыг газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах тухай журмын дагуу цахим хэлбэрээр зохион байгуулж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлж ашиглуулахыг зөвшөөрсүгэй.

2. Дуудлага худалдаа явуулах хугацаа, нөхцлүүдийг тодорхойлон нийтэд зарлан мэдэгдэж, журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Газрын даамал (О.Энхзул)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 24 өдөр

Дугаар А/151

Баянтал сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.3, 48 дугаар зүйлийн 48.2.1, Баянтал сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн “Сумын 2024 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 06 дугаар тогтоолыг 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын 2024 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-гийн хөрөнгөөр хийгдэх “Ес заншлын өргөөтэй болох /8 ханатай гэрийн модны иж бүрдэл авах/” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Ш.Шинэбаяр (Засаг даргын

Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүн:

Э.Түмэн-Эрдэнэ (Лүн багийн Засаг дарга)

Нарийн бичгийн дарга:

М.Бодьгэрэл (Нийгмийн бодлого, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2.Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулахыг ажлын хэсгийн дарга (Шинэбаяр)-д үүрэг болгосугай.

3.Ажлын хэсгийн зөвлөмжид үндэслэн шалгарсан гүйцэтгэгчийн гэрээний биелэлтэд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Баянтал сумын Засаг даргын орлогч (Э.Эрхэмбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА

D:/My Documents/2024 ajil/zahiramj.doc

421240387



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 24 өдөр

Дугаар 4152

Баянтал сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.3, 48 дугаар зүйлийн 48.2.1, Баянтал сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн “Сумын 2024 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 06 дугаар тогтоолыг 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын 2024 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-гийн хөрөнгөөр хийгдэх “Ес заншлын өргөөтэй болох /8 ханатай гэрийн туулга, бүрээс, дотор, гадна цаваг, хөшиг иж бүрдэл” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга.

Ш.Шинэбаяр (Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүн:

Л.Отгонпүрэв (Санхүү албаны дарга)

Нарийн бичгийн дарга:

М.Бодьгэрэл (Нийгмийн бодлого, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2.Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулахыг ажлын хэсгийн дарга (Шинэбаяр)-д үүрэг болгосугай.

3.Ажлын хэсгийн зөв лөмжид үндэслэн шалгарсан гүйцэтгэгчийн гэрээний биелэлтэд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Баянтал сумын Засаг даргын орлогч (Э.Эрхэмбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Э.БАТТУЛГА



D:/My Documents/2024 ajil/zahiramj.doc

421240389



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 28 өдөр

Дугаар #153

Баянтал сум

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.2, Засгийн Газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам"-ын 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр болох нийтэд зарлагдсан газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг зохион явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Э.Эрхэмбаатар (Сумын засаг даргын орлогч)

Гишүүд:

О.Энхзул(Газрын даамал түр орлон гүйцэтгэгч)

О.Дөлгөөн(Хууль, эрх зүйн мэргэжилтэн)

2.Дуудлага худалдааг хууль журмын дагуу зохион байгуулж, үр дүнг 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн дотор тайлагнахыг ажлын хэсгийн дарга (Э.Эрхэмбаатар)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Э.БАТТУЛГА





ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 28 өдөр

Дугаар А/154

Баянтал сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалт, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам" А/187 дугаар тушаалуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Боржигон овогт Амаржаргалын Хонгорзул нь (ЗН90041604) Баянтал сумын Лүн багийн Сүүл толгойн зүүн сугад байрлах Өвөлжөөний зориулалттай 700м² газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулах хүсэлт гаргасан тул 15 жилийн хугацаатайгаар сунган эзэмшүүлсүгэй.

2.Хуулийн дагуу газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулан авч буй газрынхаа орчны тохижилтыг сайжруулж, зүй зохистой эзэмшиж, газар эзэмших гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг иргэн (А.Хонгорзул)-д үүрэг болгосугай.

3.Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулан авч буй иргэн А.Хонгорзулд эзэмшил газрын кадастрын ажил гүйцэтгүүлэх хуудас болон газар эзэмших гэрээ, гэрчилгээг цахимаар үүсгэж, газрын улсын бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулахыг газрын даамал (О.Энхзул)-д зөвшөөрсүгэй.

4.Энэ захирамж гарсантай холбогдуулан Сумын Засаг даргын 2021 оны А/86 дугаар захирамжийн хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Э.БАТТУЛГА



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 28 өдөр

Дугаар А/155

Баянтал сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 38 дугаар зүйлийн 38.1, 38.4, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 5.4.2 дах зүйлийн 5.4.2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цацалмон ХХК нь (РД:2085801) Баянтал сумын 1 дүгээр багт Сүлд овооны урд талд байрлах Үйлдвэрлэлийн барилга, байгууламж бусад газрын зориулалттай 10000м² газрын газар эзэмших эрхийг шилжүүлэх хүсэлт гаргасан тул Морьтон овогтой Мөнхбаатарын Ганчимэгт (ВЛ90061129) Баянтал сумын 1 дүгээр багт Сүлд овооны урд талд байрлах 10000м² газрыг Үйлдвэрлэл барилга, байгууламж бусад газрын зориулалтаар анх авсан этгээдийн үлдсэн хугацаатайгаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Хуулийн дагуу эзэмшилдээ авч буй газрынхаа орчны тохижилтыг сайжруулж, зүй зохистой эзэмшиж, газар эзэмших гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг иргэн (М.Ганчимэг)-т үүрэг болгосугай.

3.Газар эзэмшигч иргэн М.Ганчимэгт эзэмшил газрын кадастрын ажил гүйцэтгүүлэх хуудас болон газар эзэмших гэрээ, гэрчилгээг цахимаар үүсгэж, газрын улсын бүртгэлд бүртгэн, хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (О.Энхзул)-д үүрэг болгосугай.

4.Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2012 оны А/122 дугаар захирамжыг хүчингүй болгосугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 28 өдөр

Дугаар 4/158

Баянтал сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дугаар зүйлийн 59.1.23, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 27 дугаар зүйлийн 27.1, 27.2, 33 дугаар зүйлийн 33.1.1, Засгийн газрын 2024 оны 136 тогтоолын 1 дүгээр хавсралт, Баянтал сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 08-р тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-д (РД:5081092) олгох газруудын зориулалт, эзэмших хугацаа, байршил хэмжээг хавсралтаар баталсугай.


2.Хуулийн дагуу эзэмшилдээ авч буй газрынхаа орчны тохижилтыг сайжруулж, зүй зохистой эзэмшиж, газар эзэмших гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-д үүрэг болгосугай..

3.Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-д эзэмшил газрын кадастрын ажил гүйцэтгүүлэх хуудас болон газар эзэмших гэрээ, гэрчилгээг цахимаар үүсгэж, газрын улсын бүртгэлд бүртгэн, хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (О.Энхзул)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА



Баянтал сумын Засаг даргын 2024 оны
10 сарын 28-ны өдрийн 1156 дугаар
захирамжийн хавсралт



Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-ний
эзэмшилд олгох газрын жагсаалт

Д/д	Нэр	Газар эзэмших хугацаа /жил/	Газрын хэмжээ /м ² /	Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар	Газрын зориулалт	Газрын байршил, нэр
1	Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК	15	75	3745707	3411: Холбоо мэдээлэл дамжуулах шугам	Баянталын хойд хилээс Сүмбэрийн хил хүртэл
2	Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК	15	3124	3745708	3411: Холбоо мэдээлэл дамжуулах шугам	Баянталын хойд хилээс Сүмбэрийн хил хүртэл
3	Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК	15	6665	3745709	3411: Холбоо мэдээлэл дамжуулах шугам	Баянталын хойд хилээс Сүмбэрийн хил хүртэл
4	Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК	15	13206	3745710	3411: Холбоо мэдээлэл дамжуулах шугам	Баянталын хойд хилээс Сүмбэрийн хил хүртэл
5	Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК	15	370	3745712	3411: Холбоо мэдээлэл дамжуулах шугам	Баянталын хойд хилээс Сүмбэрийн хил хүртэл
6	Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК	15	25082	3745713	3411: Холбоо мэдээлэл дамжуулах шугам	Баянталын хойд хилээс Сүмбэрийн хил хүртэл
7	Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК	15	6612	3745715	3411: Холбоо мэдээлэл дамжуулах шугам	Баянталын хойд хилээс Сүмбэрийн хил хүртэл
8	Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК	15	15000	3745718	3411: Холбоо мэдээлэл дамжуулах шугам	Баянталын хойд хилээс Сүмбэрийн хил хүртэл
9	Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК	15	213375	3745711	3411: Холбоо мэдээлэл дамжуулах шугам	Баянталын хойд хилээс Сүмбэрийн хил хүртэл



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 29 өдөр

Дугаар А/157

Баянтал сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.5, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолын “Барилга ажлын захиалагчийн дүрэм” хавсралтын 2.7 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Баянтал суманд 2024 онд хэрэгжүүлэх барилга байгууламжийн угсралт, засварын ажилд захиалагчийн хяналт хийлгэх гэрээ /Спорт заалны барилга барих/ ажилд зориулж 10,336,577 /арван сая гурван зуун гучин зургаа мянга таван зуун далан долоо/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Дээрх хөрөнгийг 2024 оны Спорт заалны барилга шинээр барих ажлын захиалагчийн хяналтын зүрдлаас гаргахыг Орон нутгийн хөгжлийн сангийн зардлаас санхүүжүүлэхийг санхүү албаны ерөнхий нягтлан бодогч (Б.Солонгомаа)-д даалгасугай

3.Захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Э.Эрхэмбаатар)-д үүрэг болсугай.



ДАРГА

Э.БАТТУЛГА



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 29 өдөр

Дугаар А/158

Баянтал сум

Ажил хүлээн авах комисс
томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжүүлэх журам”-ын 4.13 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 2023 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжсэн “Сумын төвийн гэрэлтүүлэг засвар” ажлыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Р.Ариунсанаа (ЗДТГ-ын аж ахуйн нярав)

Гишүүн:

Б.Эрдэнэ-очир(ЦТЦ-ын шуурхай үйлчилгээ,
засварын мончёр Иргэний төлөөлөл)

Нарийн бичгийн дарга:

М.Бодьгэрэл (Нийгмийн бодлого, худалдан
авах ажиллагаа хариуцсан
мэргэжилтэн)

2. Тендерийн баримт бичиг, гэрээнд заасны дагуу ажлын тоо хэмжээг тулган үзэж, чанартай гүйцэтгүүлж, хүлээн авахыг ажлын хэсгийн комиссын гишүүдэд даалгасуга

3. “Сумын төвийн гэрэлтүүлэг засвар” ажлыг ажлын хэсгийн комиссын зөвлөмжид дүгнэлтийг үндэслэн, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтаар бий болсон өмч хөрөнгийг бүртгэл, тайланд тусгаж, эзэмшил ашиглалтад хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ш.Шинэбаяр)-д үүрэг болгосугай

ДАРГА



Э.БАТТУЛГА